

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
4 дүгээр хороо, Ж.Самбуугийн гудамж,
Нийслэлийн засаг захиргааны III байр
Утас: 7011-1284, Факс: (976-11) 31-15-09
E-mail: ub_info@inspection.gov.mn
http://www.ub.inspection.gov.mn

2017.02.10 № 02-01/532
танай _____-ны № _____-т

Мэдэгдэл хүргүүлэх тухай

Улсын хэмжээнд 2017 он гарсаар Төв аймгийн Баяндэлгэр, Архуст, Заамар, Борнуур, Баян, Цээл, Сүмбэр, Булган аймгийн Могод, Гурванбулаг, Рашаант Архангай аймгийн Хашаат, Өгийнуур, Дархан-Уул аймгийн Хонгор, Дундговь аймгийн Эрдэнэдалай, Цагаандэлгэр, Говь-Угтаал, Баянжаргалан, Адаацаг, Дархан-Уул аймгийн Хонгор, Сэлэнгэ аймгийн Хүдэр, Сүхбаатар аймгийн Мөнххаан, Түвшинширээ, Дорноговь аймгийн Дэлгэрэх, Сайншанд, Сэлэнгэ аймгийн Хүдэр, Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, Жаргалтхаан, Баян-Адрага, Биндэр, Мөрөн, Хэрлэн сум, Нийслэлийн Налайх дүүрэг зэрэг нийт 11 аймгийн 32 суманд хонины цэцэг өвчин, Дорнод аймгийн Матад, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Асгат, Баруун-Урт, Сүхбаатар зэрэг 2 аймгийн 5 суманд малын гоц халдварт шүлхий өвчин, лабораторийн шинжилгээгээр онош нь батлагдсантай холбогдуулан Нийслэлийн нутаг дэвсгэрт өвчний халдвар дамжин тархах болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсын Малын удмын сан эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5.3, 4.5.4, 4.5.8, 4.5.10 дах заалтууд, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 85 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн нутаг дэвсгэрт мал аж ахуй эрхлэх журам"-ын 4.1, 6.9, 6.10 дах заалтуудын дагуу дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

1. Мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсэд байршиж буй мал амьтны тоо судалгааг гаргаж, сууршлын бүсээс нүүлгэн шилжүүлэх;
2. Өвчний голомт болон сэжигтэй бүс нутгаас мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг нийслэл болон өөр бусад аймаг суманд тээвэрлэх, худалдахыг өвчний дэгдэлт, тархалтыг бүрэн зогсох хүртэл хориглох;
3. Бүх төрлийн малын шилжилт хөдөлгөөнийг зогсоох, алдуул болон тавиул малд тавих хяналтыг чангатган, малчдад малаа байнгын хариулга, маллагаатай байлгах талаар анхааруулга, сэрэмжлүүлэг өгч ажиллах;
4. Хорио цээр, хязгаарлалт тогтоосон бүс болон авто тээврийн шалган бүртгэх, дамжин өнгөрөх товчоо, цэгүүдэд ариутгал, халдваргүйжүүлэлтийн байр, ариутгал халдваргүйжүүлэх цэг байгуулах асуудлыг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж шийдвэрлэх;

1150500542

5. Авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоо болон дамжин өнгөрөх цэгүүдэд орон нутгаас ирж байгаа зорчигч, тээврийн хэрэгсэл, тээвэрлэгдэн, тууварлан ирж буй мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарал, үүсэлд тавих хяналтыг чангатгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

6. Дүүрэг, орон нутагт овоо, тахилга, хурдан морины уралдаан, мал амьтныг нэг дор цугларуулах зэргээр олон нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулахыг хязгаарлах;

7. Орон нутагт мал, амьтны бусад төрлийн халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлэх, өвчнөөр болон зүй бусаар үхэж хорогдсон малын сэг, зэм устгах ажлыг эрчимжүүлэх, өвөлжөө, хаваржаа, өтөг бууц, хашаа саравч, малын тоног хэрэгсэлд хийх ариутгал халдваргүйтгэлийн ажлыг орон нутгийн мэргэжлийн байгууллагуудаар хийлгүүлж хяналт тавих;

8. Өвчний голомттой хил залгаа айл өрх, аймаг, сумдын мал бүхий иргэдийн малд эрүүл мэндийн үзлэг тандалт хийх ажлыг бүрэн эрхийнхээ хүрээнд зохион байгуулна.

Монгол Улсын Малын удмын сан эрүүл мэндийн хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх "Малын өвчинтэй тэмцэх, удмын санг хамгаалах ажлыг зохион байгуулахад төрийн захиргааны төв байгууллага, эрх бүхий бусад байгууллагаас гаргасан шийдвэр, дүрэм, журмыг биелүүлэх" заалтыг зөрчсөн хуулийн этгээд, албан тушаалтанд хариуцлага тооцохыг мэдэгдье.

ДАРГА



Л.ЭРДЭНЭЧУЛУУН